

БАТЛАВ:
ГУРВАНБУЛАГ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ
ДАРГА Ц.ЭНХБОЛД

ГУРВАНБУЛАГ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНЫ 2020-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 оны 06 сарын 24 өдөр

Пионер толгой

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 Орлоготой иргэн

- 1.1.1 Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлнэ.
- 1.1.2 Орон нутгийн түвшинд хөгжих боломжтой жижиг дунд үйлдвэрлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.1.3 “Хуримтлалтай хонгорчууд” хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагтаа эрчимжүүлж “Хүүхэд бүрийг хадгаламжтай болгох”, “Хуримтлалтай хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.4 30 айлын хаус хорооллыг барьж дулааны шугамд холбоно.

1.2 Эрүүл иргэн


- 1.2.1 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааны төв байгуулна.
- 1.2.2 “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг /ангина/ өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлнэ.
- 1.2.3 Элэг бүтэн Баянхонгор” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2.4 Гурванбулаг суманд шинээр эрүүл мэндийн төв барьж ашиглалтад оруулна.

1.3 Чанартай боловсрол шинжлэх ухаан, инновацын хөгжил

- 1.3.1 Боловсролын салбарын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.2 160 хүүхдийн Бага сургуулийг барьж ашиглалтад оруулна.
- 1.3.3 Сургуулийн сурагчдын дотуур байрыг барьж ашиглалтад оруулна.
- 1.3.4 Зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.3.5 Хүүхэд, багачуудын бие даах чадварыг нэмэгдүүлж, хөгжүүлж, тэдний төлөвшлийг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 1.3.6 Залуучуудын хөгжил төлөвшлийг сайжруулж, нийгмийн оролцоог нэмэгдүүлж, идэвхтэй амьдралыг нь дэмжсэн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.3.7 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, нийгмийн хамгаалал, хөгжлийг сайжруулах” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.8 Ахмад настанд үзүүлэх үйлчилгээг сайжруулна.



000000001



ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1 Гудамж хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.
- 2.2 Заг Гурванбулагийн хоорондох агаарын шугамын шинэчлэлийг хийнэ.
- 2.3 Жи Мобайлын сүлжээг өргөтгөн тархалтыг нэмэгдүүлнэ.
- 2.4 Нутгийн удирдлагын ордон шинээр барьж ашиглалтад оруулна

ГУРАВ . ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 3.1 Төрийн байгууллага бүрд төрийн албан хаагчийн “Нийгмийн баталгааг хангах” хөтөлбөр, төрийн албан хаагчийн “Сургалтын хөтөлбөр”ийг батлуулан хэрэгжүүлэх.

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 4.1 Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэгдсэн газруудын нөхөн сэргээлтийг хийнэ.

ТАВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ

- 5.1 Хөдөө аж ахуйн салбарт малчдын залгамж халааг бэлтгэх "Илгээлтийн эзэн-III" аяныг хэрэгжүүлнэ.
- 5.2 "Монгол мал-2" хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, малын гений санг хамгаалах, эрүүл бүсээ хадгална.
- 5.3 Бэлчээр ашиглалтыг сайжруулж малчны байгууллагын үйл ажиллагааг бодлогоор дэмжин ажиллана.

ГУРВАНБУЛАГ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО



43544
7 9007423

000000002